

**ХӨСӨГ ТРЕЙД ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 02 сар 2 /өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит бус хурлыг 2022 оны 02-р сарын 21-ний өдрийн 11.30 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Ж.Энхтунгалаг 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Д.Бадам 88118 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
С.Жавзан-Орлом 51939 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Г.Маргад 53916 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Эй ди эм эм ди ХХК, түүний гүйцэтгэх захирал Ж.Гантогтох 96357 ширхэг хувьцааны саналаар 295,793 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 98.1 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигч ердийн болон хараат бус гишүүд Т.Өлзийбүрэн, Р.Гансүх, Ц.Дамжин нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга С.Болор удирдав.

Хурлаар:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох
2. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох асуудлыг тус тус хэлэлцэв.

-Хурлын дарга С.Болор: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулъя. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын гишүүн П.Сэлэнгэ хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 98.1% хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69 1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зовшоорлийг хурлын даргад өгөв.

Хурал 11.30 минутанд эхлэв.

СОНССОН НЬ :

- Хурлын дарга С.Болор: Хөсөг трейд ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал маань 2022 оны 01 сарын 21-ний өдөр болохоор Эй ди эм эм ди ХХК-ийн саналын дагуу зарлагдан хуралдаж байна. Эй ди эм эм ди ХХК-иас компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон тухай баримтуудыг ирүүлсэн тул Төлөөлөн удирдах зөвлөлөөс хурлыг зарласан байна. Та бүхэнд цаг заваа гарган хуралд ирсэнд талархал илэрхийлье. Онөөдрийн ээлжит бус хурлаар та бүхэнд тараасан материалд заасан дэгийн дагуу дараах асуудлыг хэлэлцэнэ. Ингээд хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулъя.

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох :
2. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох асуудлыг тус тус хэлэлцэнэ.

Нэр дэвшигч нарыг танилцуулъя. Та бүхэнд тараасан материалд нэр дэвшигч нарын дэлгэрэнгүй анкет байгаа бөгөөд нэр дэвшигч нарыг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч Ж.Гантогтох, С.Жавзан-Орлом, Д.Бадам, Г.Маргад, С.Бат-Өлзий, С.Болор, харин хараат бус гишүүнд нэр дэвшигч Т.Өлзийбүрэн, Р.Гансүх, Ц.Дамжин, Т.Мөнхжаргал нар байна.

За одоо эдгээр ингээд өмнөх Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг дуусгавар болгож шинээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар Тооллогын комиссоос та бүхэнд зааварчилгаа болон кумулятив аргыг танилцуулах болно.

- **Тооллогын комиссын гишүүн И.Сэлэнгэ:** Та бүхэнд тараасан саналын хуудас болон түүний арын хэсгийг харвал кумулятив аргаар санал зааврыг дэлгэрэнгүй тусгасан байгаа хэмээн санал хуудас бөглөх зааварчилгааг өгөв.

- **Хурлын дарга С.Болор:** хувьцаа эзэмшигчид саналаа саналын хуудсаар өгнө үү.

Хурал 15 минут завсарлая. Завсарлаад шинээр сонгогдсон ТУЗ-ийн санал хураасан дүнг танилцуулна.

Асуух зүйл байна уу.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа завсарлах уу.

- **Хурлын дарга С.Болор:** За ингээд тооллогын комисс санал хураалтыг дуусгасан байгаа тул танилцуулна уу.

- **Тооллогын комиссын гишүүн И.Сэлэнгэ:** Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсыг тоолж дууслаа. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя. 2022 оны 02 сарын 21-ний 02 дугаар тогтоол, санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай, Монгол улсын компанийн тухай хуулийн 67 дугаар зүйл санал хураах хуудсаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцээд тогтоох нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох дээр зөвшөөрсөн 5 буюу нийт гаргасан хувьцааны 290,331 ширхэг буюу 98.1 хувиар зөвшөөрсөн байна.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүн сонгох дээр 5 буюу нийт гаргасан хувьцааны 290,331 ширхэг буюу 98.1 хувийн хувьцаа эзэмшигч дараах байдлаар санал өгсөн байна.

- Ж.Гантогтох 290,331 ширхэг, - С.Жавзан-Орлом 290,331 ширхэг, - Д.Бадам 290,331 ширхэг, - Г.Маргад 290,331 ширхэг, - С.Бат-Өлзий 290,331 ширхэг, - С.Болор 290,331

ширхэг, харин хараат бус гишүүнд нэр дэвшигч Т.Өлзийбүрэн 290,331 ширхэг, Р.Гансүх 290,331 ширхэг, Ц.Дамжин 290,331 ширхэг саналыг тус тус авснаар сонгогдсон байна.

- **Хурлын дарга С.Болор:** За ингээд тооллогын комиссын тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Хурлын дарга тогтоолын төслийг уншиж танилцуулснаар хурлаар хэлэлцэх асуудал дуусав.

- **Хурлын дарга С.Болор:** Компанийн дүрмийн дагуу төлөөлөн удирдах зөвлөл нь 3 жилийн хугацаатай томилогдож байгааг дурдах нь зүйтэй болов уу.

За ингээд Хэлэлцэх асуудал дуусав.

өөр санал байна уу? Байхгүй бол саналаа хураагаад хурлаа өндөрлөө.

ТУЗ-ийн хурлыг үргэлжлүүлэн хийхээр тогтов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосугай.
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.
 - Ж.Гантогтох
 - С.Жавзан-Орлом
 - Д.Бадам
 - Г.Маргад
 - С.Бат-Өлзий
 - С.Болор
3. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.
 - Т.Өлзийбүрэн
 - Р.Гансүх
 - Ц.Дамжин
- 4 Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 12 цаг 30 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



/С.БОЛОР/

/А.АРИУНСАЙН/